

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДРИЙН ЭЭЛЖИТ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 4 дүгээр сарын 22

Улаанбаатар хот


Д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хувь
1	<p>Үүрэг, даалгавар НЭГ: Засгийн газрын 2025 оны 15 дугаар хурлын тэмдэглэлийн дагуу Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, эдийн засгийн үр ашгийн талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах.</p> <p>- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх “Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг)” төсөл, арга хэмжээний зураг төсөв болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн “Эрх шилжүүлэх тухай” 2025 оны А/187 дугаар захирамжийг дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 3/714 тоот албан бичгээр хүргүүлсэн. - Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх “Чингэлтэй дүүргийн Нутгийн захиргааны байрны барилга (Улаанбаатар хот)” төсөл арга хэмжээний холбогдох баримт болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Эрх шилжүүлэх тухай захирамжийг 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 3/357 тоот албан бичгээр дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/186 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан “Эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалт, их засварын ажил (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг)” төсөл, арга хэмжээний жагсаалтыг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-д тус тус хүргүүлэн ажилласан.</p> <p>- Тендер шалгаруулалтад оролцож буй аж ахуйн нэгж, байгууллагын оролцоо үйл ажиллагааг тэгш боломжоор хангаж, өрсөлдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж байна. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан ажлын төлөвлөгөөг дахин эрэмбэлж, эдийн засгийн үр ашгийн талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна.</p>			70



<p>Үүрэг, даалгавар ХОЁР: Засгийн газраас 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд саналаа тодорхой тусгаж, хүргүүлэх.</p>	<p>Монгол Улсын Засгийн газраас 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан дүүргийн хэмжээнд боловсролын салбарт хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, ашиглалтад бүрэн оруулах зорилт тавин ажиллаж байна. Энэ хүрээнд дүүргийн 8 дугаар хорооны 640 хүүхдийн суудал бүхий сургуулийн барилга (гүйцэтгэл 25%), 12 дугаар хорооны 240 хүүхдийн суудалтай бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (гүйцэтгэл 90%), 19 дүгээр хорооны 240 хүүхдийн суудалтай бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (гүйцэтгэл 70%), 17 дугаар хорооны 960 хүүхдийн суудал, спорт заал бүхий сургуулийн барилгын ажлын газар чөлөөлөлт хийгдэж байгаа бөгөөд уг ажлуудыг эрчимжүүлэхээр ажиллаж байна.</p>	<p>Үүрэг, даалгавар ТАВ: 2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 08:00 цагт СТӨ-нд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг эрчимжүүлэх чиглэлээр шуурхай зөвлөгөөн зохион байгуулах.</p>	<p>2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр СТӨ-нд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг эрчимжүүлэх чиглэлээр зохион байгуулагдсан шуурхай зөвлөгөөнд дүүргийн Засаг дарга, Худалдан авах ажиллагааны албаны дарга, Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга нар оролцсон.</p>	<p>Үүрэг, даалгавар ДОЛОО: Нийслэлийн хэмжээнд соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соён гэгээрүүлэх ажлуудыг эрчимжүүлэн, Нийгмийн салбарын байгууллагууд нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр соён гэгээрүүлэх чиглэлээр хийсэн ажлын талаар танилцуулах.</p>	<p>- Нийслэлийн 9 дүүргийн дунд зохион байгуулсан “Өвлийн фестиваль” арга хэмжээнд дүүргийн 200 гаруй ажилтан, албан хаагч, иргэдийг хамруулж, тэргүүн байрт шалгарсан амжилтыг үзүүлсэн.</p> <p>- Б.Явуухулангийн нэрэмжит яруу найраг"-ийн тэмцээнийг 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, дүүргийн Ерөнхий боловсролын 15 сургуулийн 30 гаруй сурагчид хамрагдсан. Мөн 2025 оны 3 дугаар сарын 15-ны өдөр яруу найргийн дурсамж, өдөрлөгийг Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулсан.</p> <p>- Дүүргийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдлагуудад Хүүхэд багачуудын бие даалтын 7 хоногт музейн үзвэрээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх боломжтой талаар болон Хүүхэлдэйн театр"-аас сургуулийн амралтыг тохиолдуулан төлбөрийн 30% хөнгөлөлттэй үнээр үйлчилж байгаа мэдээллийг хүргэж ажилласан.</p> <p>- Соёлын биет бус өв болох уртын дуу, бий биелгээг дэлгэрүүлэх, таниулан сурталчлах зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Завсарлагааны дуу, бүжиг” аяныг 2025 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 5 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд өрнүүлж, ерөнхий боловсролын нийт 18 сургуулийн 12000 гаруй хүүхэд хамрагдаж байна.</p>
<p>2</p>	<p>70</p>		<p>100</p>	<p>100</p>	

- Ардын уран зохиолч Дэндэвийн Пүрэвдоржийн “Тусгаар тогтнол” шүлгийг нэг цагт, нэгэн зэрэг унших арга хэмжээг Чингэлтэй дүүрэгт “Тусгаар тогтнол”-ын талбайд 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 12:00 цагт зохион байгуулсан.
- Монгол Улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах, нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Соёлтой иргэн-2028” арга хэмжээний хүрээнд Чингэлтэй дүүргийн Засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын “Урлагийн наадам”-д нийт 10 байгууллагын 300 гаруй албан хаагчид оролцлоо.
- Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Чингэлтэйн фестиваль-2025” арга хэмжээг 2025 оны 5 дугаар сарын 17-ны өдөр дүүргийн хэмжээнд зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Үүрэг, даалгавар ХОРИН НЭГ: Нийтийн эзэмшлийн талбайг хашаалсан автомашины зогсоолыг чөлөөлж, ТҮЦ, хашаа, хайс, гарааш буулгах ажлыг эрчимжүүлэх.

Нийтийн эзэмшлийн зам, талбайд зөвшөөрөлгүй болон зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн барьсан хашаа хайсыг буулгах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 оны 4 дүгээр сарын 18-ны байдлаар ТҮЦ арга хэмжээ хөтөлбөрт 87 түүц, нийт 10 байршилд 420 метр хашаа, хайсыг чөлөөлсөн.



				<p>Үүрэг, даалгавар ХОРИН ГУРАВ: Дулааны улирал ирж, хүүхэд, залуучуудын хөдөлгөөн ихсэж байгаатай холбогдуулан гэмт хэрэг, зөрчил болон зам, тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.</p>
<p>6</p>		<p>- Цаг агаар дулаарч хүүхэд багачууд замын хөдөлгөөнд хоёр дугуйт тээврийн хэрэгсэлтэй, явганаар хөдөлгөөнд оролцож, зам тээврийн осолд өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн ерөнхий боловсролын 17 сургуулийн 10-12 дугаар ахлах ангийн 510 сурагчид сургалт зохион байгуулсан. Мөн суррон тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцсон нийт 48 зөрчлийг илрүүлж, Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хариуцлага тооцож ажилласан.</p>		<p>70</p>
		<p>- MNS4598:2025 стандартын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хоёр дугуйт суррон болон 50сс-ас дээш хурдлах хүчин чадал бүхий мопед төрлийн тээврийн хэрэгслийг Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн А ангилалд багтах, 18 насанд хүрсэн иргэн жолоодон замын хөдөлгөөнд оролцох талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд телевизэд 2, сайтад 1, фм 1, нийт 4 мэдээ мэдээлэл сэрэмжлүүлэг хүргэн ажилласан.</p>	<p>- Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгийг бага насанд нь эзэмшүүлэх зорилготой "Замын хөдөлгөөний цагаан толгой" уралдаант тэмцээнийг жил бүрийн 2 дугаар улиралд сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулан ажиллаж байна. Тэмцээн зохион байгуулалтын шатандаа явж байна.</p>	

<p>- Хүүхдийг зодож шийтгэхгүй байх Дэлхийн өдрийг угтан "Шийтгэл бол Шийдэл биш" аяныг өрнүүлж байна. Тус аяны хүрээнд хүүхдийг гэмт хэрэг зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлье", "Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт", "Уе тэнгийн дарамт дээрлэхэлт" сэдэвт өртөөчилсөн сургалтыг дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж 5 сургуулийн 426 хүүхэд сургалтад хамрагдаад байна.</p>			
<p>ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ</p>			<p>80%</p>



ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

О.БАТМӨНХ

НЭГТГЭЛИЙГ ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Т.БАТЦЭЦЭГ

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Э.БУЯН-ӨЛЗИЙ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ШУУРХАЙН БИЕЛЭЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

В.ИНИННОРОВ

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

В.УРАНЧИМЭГ